



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/85

Бор-Өндөр сум

Мал, амьтны сэг зэм устгал, орчны  
халдваргүйтгэл, арга хэмжээг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дугаар зүйлийн 59.1.13, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны А/181 дугаар Захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны сэг, зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Болормаа

Мал эмнэлгийн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга

Р.Цэндсүрэн

Тархвар зүйч

Гишүүд

И.Энхтуяа

Бор-Өндөр 1 дүгээр Багийн Засаг дарга

У.Пүрэвсүрэн

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Д.Мөнгөнтуяа

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Ч.Саруулмөнх

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Мөнх-Оргил

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Н.Отгонбилэг

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Ц.Бат-Эрдэнэ

“Ноён Зүлэгт” ХХК-ний МЭҮН-ийн захирал

Ц.Төртүвшин

“Эн Тэ Чи” ХХК-ний МЭҮН-ийн захирал

2. Мал, амьтны сэг, зэмээс малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг, зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 2025 оны 05 дугаар сарын 01-ний

өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн Малын эмч (Ц.Бат-Эрдэнэ, Ц.Төртүвшин) нарт, Мал, амьтны сэг, зэмийг цулуулж устгах, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Болормаа)-д даалгасугай.

4. Мал, амьтны сэг, зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээнд ажилгүй иргэдийг татан оролцуулах, түр ажлын байраар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, төсөл хөтөлбөрийн хүрээнд ажлын хөлсийг холбогдох журмын дагуу олгохыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн (Э.Рагчаадулам)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д, ажлын гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ